



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 646

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газар түүний харьяа хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 5 нэрийн, нийт 354,480,000.00 (гурван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун наян мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 53,172,000.00 (тавин гурван сая нэг зуун далан хоёр мянган) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга А.Ариунболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 сарын 27-ны өдрийн
696 дугаар тогтоолын хавсралт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
үлдэгдэл өртөггүй, ашиглах хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоох тээврийн хэрэгслийн жагсаалт

| Д/д | Байгууллагын нэр | Үндсэн хөрөнгийн нэр, төрөл | Ашиглалтад орсон огноо | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг) | Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг) | | Цаашид ашиглах хугацаа /жилээр/ |
|-----|---|--|------------------------|-------------------------|------------|--|-------------------------------|--|---------------------------------|
| | | | | | | | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) | |
| 1 | Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | Ford Everest, 69-89 БУЛ | 2016-04-18 | 89,980,000.00 | 1 | 89,980,000.00 | 13,497,000.00 | 13,497,000.00 | 4 |
| 2 | Говь-Алтай аймгийн НДХ | Ford Everest, 11-89 ГАУ, | 2015.04.03 | 69,900,000.00 | 1 | 69,900,000.00 | 10,485,000.00 | 10,485,000.00 | 4 |
| 3 | Завхан аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | Жип, Ford Everest, 22-893АН, MNCLS4D10CW40223 6, 2490В | 2015.05.01 | 69,800,000.00 | 1 | 69,800,000.00 | 10,470,000.00 | 10,470,000.00 | 4 |
| 4 | Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | Форд эвэрэст, 34-89 СҮЭ, MNCL4D10CW401713 , 2490В | 2015.04.01 | 69,900,000.00 | 1 | 69,900,000.00 | 10,485,000.00 | 10,485,000.00 | 4 |
| 5 | Багануур дүүргийн НДХ | Соната-8, 85-85 БРА | 7/1/2016 | 54,900,000.00 | 1 | 54,900,000.00 | 8,235,000.00 | 8,235,000.00 | 4 |
| | | Нийт дүн | | | 5 | 354,480,000.00 (гурван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун наян мянга) | | 53,172,000.00 (тавин гурван сая нэг зуун далан хоёр мянга) | |